# Бүгд Найрамдах Чех улсад хөдөлмөр эрхлэх – *DPP болон DPČ*

**БНЧУ-д үндсэн хөдөлмөрийн гэрээнээс гадна DPP эсвэл DPČ гэсэн гэрээнүүдтэй бас тулгарч болно.**

| **DPP – ажил гүйцэтгэх гэрээ** | **DPČ – ажил гүйцэтгэх удаан хугацаатай гэрээ** |
|---|---|
| Бичгээр хийсэн байх ёстой – DPP-ийн нэг эх хувь нь танд зориулагдсан болно. | Бичгээр хийсэн байх ёстой – DPČ-ийн нэг эх хувь нь танд зориулагдсан болно. |
| Нэг ажил олгогч дээр хуанлийн жилд дээд тал нь 300 цаг ажиллах гэрээ хийж болно. | Нэг ажил олгогч дээр долоо хоногт дээд тал нь 20 цаг ажиллах гэрээ хийж болно. |
| Гэрээнд дараах зүйлийг багтаасан байх ёстой: ажлын төрөл, цагийн хөлс мөн DPP гэрээ байгуулагдсан хугацаа. | Гэрээнд дараах зүйлийг багтаасан байх ёстой: ажлын төрөл, цагийн хөлс мөн DPČ гэрээ байгуулагдсан хугацаа. |
| Цалигийн 15%-ийг татварт суутгана. | Цалигийн 15%-ийг татварт суутгана. |
| Хэрэв сарын цалин нь 10,000 кроноос бага бол ажил олгогч таны эрүүл мэндийн болон нийгмийн даатгалыг төлөхгүй. | Хэрэв сарын цалин нь 2,500 кроноос бага бол ажил олгогч таны эрүүл мэндийн болон нийгмийн даатгалыг төлөхгүй. |
| Хэрэв сарын цалин нь 10,000 кроноос дээш бол ажил олгогч таны эрүүл мэндийн болон нийгмийн даатгалыг төлнө. | РХэрэв сарын цалин нь 2,500 кроноос дээш бол ажил олгогч таны эрүүл мэндийн болон нийгмийн даатгалыг төлнө. |
| Та амралт болон илүү цагийн цалин авах эрх байхгүй. | Та амралт болон илүү цагийн цалин авах эрх байхгүй. |
| DPP дуусах үед …<br>…тохиролцсон ажлын төрлийг гүйцэтгэсэн,<br>…тохиролцсоны дагуу ажилсан цагийн тоо,<br>...хуанлийн жилд хамгийн их ажиллах цаг буюу 300 цаг ажилласан<br>…DPP-г тохиролцон цуцлах – та гэрээ цуцлах өргөдөл авах эсвэл өгөх (өргөдлийн хугацаа 15 хоног бөгөөд ажил олгогчид өгсөн өдрөөс эхэлнэ). | DPČ дуусах үед …<br>…тохиролцсон ажлын төрлийг гүйцэтгэсэн,<br>…тохиролцсоны дагуу ажилсан цагийн тоо,<br>…DPČ-г тохиролцон цуцлах – та гэрээ цуцлах өргөдөл авах эсвэл өгөх (өргөдлийн хугацаа 15 хоног бөгөөд ажил олгогчид өгсөн өдрөөс эхэлнэ). |
| Та өвчний тэтгэлэг авах эрхгүй. | Та өвчний тэтгэлэг авах эрхтэй. |

Та дэлгэрэнгүй мэдээллийг дараах цахим хуудаснаас авах боломжтой: https://www.suip.cz/pracovne-pravni-vztahy-otazky-a-odpovedi

**ХЭРВЭЭ ТА НӨХЦӨЛ БАЙДАЛДАА ИТГЭЛГҮЙ БАЙВАЛ ГАДААД ИРГЭДЭД ТУСЛАХ ТӨВӨӨС ЗӨВЛӨГӨӨ АВАХ НЬ ДЭЭР, БИД ТАНД ТУСЛАХДАА БАЯРТАЙ БАЙХ БОЛНО. УУЛЗАЛТЫН ЦАГАА УРЬДЧИЛАН ТОВЛООРОЙ.**

FINANCOVÁNO EVROPSKOU UNIÍ AZYLOVÝ, MIGRAČNÍ A INTEGRAČNÍ FOND

MINISTERSTVO VNITRA ČESKÉ REPUBLIKY

CENTRUM CIZINCŮ

Poradna pro integraci

Projekt "Centrum na podporu integrace cizinců v Ústeckém kraji" AMIF/31/03 je financován Evropskou unií v rámci národního programu Azylového, migračního a integračního fondu a rozpočtu Ministerstva vnitra České republiky.